

## ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан 2000 оны Дархлаажуулалтын тухай хуулийг дагаж мөрдснөөс хойш цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн захиалга, хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах шаардлагаар уг хуульд олон удаа нэмэлт өөрчлөлт оруулсан. Дээрх нэмэлт өөрчлөлтүүд нь дархлаажуулалтын үйл ажиллагааг төрөөс дэмжин, заавал хийх дархлаажуулалтын нэр, төрлийг нэмэгдүүлж, дархлаажуулалтын тухай хууль тогтоомж, дархлаажуулах бэлдмэлд тавих улсын хяналт, хангамжийн талаар шинэчлэн баталсан олон давуу талтай байна.

Одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа Дархлаажуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Заавал хийх дархлаажуулалтад сүрьеэ, халдварт саа (полиомиелит), В вируст гепатит, сахуу, хөхүүл ханиад, татран, улаанбурхан, В хэв шинжийн хемофилюс инфлюенза нянгийн халдвар, гахайн хавдар, улаануудын эсрэг сэргийлэх тарилга орно” гэж заасан байна.

Монгол Улс 1987 оноос дархлаажуулалтын товлотыг бий болгож, 1991, 1993, 2006, 2009 онд шинэчлэн баталсан. “Дархлаажуулалтын үндэсний товлотыг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 185 дугаар тогтоолыг улсын хэмжээнд мөрдөн ажиллаж байна. Уг тогтоолд зааснаар заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлотын дагуу 10 халдварт өвчний эсрэг 6 төрлийн вакцинаар 0-15 насны хүүхдүүдийг дархлаажуулж, дархлаажуулалтын хамралт 95 хувь ба түүнээс дээш байна.

Монгол Улс 1923 оноос цагаан цэцэг, 1962 оноос полиомиелит, 1966 оноос сахуу, татран, хөхүүл ханиад, 1974 оноос улаанбурхан, 1987 оноос сүрьеэ, 1991 оноос В вируст гепатитын халдварын эсрэг вакциныг дархлаажуулалтад нэвтрүүлсний үр дүнд 1940 оноос цагаан цэцэг, 2000 оноос полиомиелит өвчнийг устгаж, дархлаажуулалт бүхий бусад халдварт өвчнийг хяналтад аваад байна.

Хүн амын дундах өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болох амьсгалын тогтолцооны өвчлөлийн дотор уушгины хатгалгаа өвчин 51.2 хувийг эзэлж, пневмококкоор үүсгэгдсэн уушгины хатгалгаа өвчин 2 хүртэлх насны хүүхдүүдийн дундах өвчлөл, нас баралтын гол шалтгаан болж байсан. Үүнтэй холбоотой 2016 оноос Австрали улсын Мелбурн хотын Мурдокийн хүүхдийн өвчин судлалын төв болон Монголын судлаачид хамтран пневмококкийн эсрэг 13 цэнт вакциныг улсын хэмжээнд үе шаттай нэвтрүүлсэн. Судалгааны үр дүнд пневмококкоор үүсгэгдсэн уушгины хатгалгаа 26 хувь, хүнд хэлбэрийн хатгалгаа 42 хувь, маш хүнд хэлбэрийн хатгалгаа 46 хувиар тус тус буурсан үр дүнтэй байна.

Дэлхийн 195 улс оронд 1990-2016 он хүртэлх хугацаанд оношлогдсон уушгины үрэвслийн тоон мэдээг судалсан судалгаанаас харахад амьсгалын доод замын үрэвсэл хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж, дэлхий нийтэд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгааныг амьсгалын доод замын халдвар эзэлж байна. 2016 онд дэлхий нийтэд бүртгэгдсэн амьсгалын доод замын халдварын шалтгаант нас баралтын 61,4%-ийг 5 хүртэлх насны хүүхэд эзэлж байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын мэдээлснээр 5 хүртэлх насны хүүхдийн 14 хувь нь уушгины хатгалгаа өвчнөөр нас барж, 39 секунд тутам уушгины

үрэвслийн улмаас дэлхийд 1 хүүхэд эндэж байна. Хамгийн гол нь уг өвчин урьдчилан сэргийлэх боломжтой халдварт өвчин юм.

2020 оны байдлаар Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын гишүүн 194 орноос 148 улс нь пневмококкийн эсрэг вакциныг дархлаажуулалтын үндэсний товллод нэвтрүүлсэн байна.

2011 оноос өмнө ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд А вируст гепатитын халдварын дэгдэлт бүртгэгдэж, жил бүр 9000 гаруй хүүхэд шинээр өвчилж, өвчлөгсөдийн 70 гаруй хувийг 9 хүртэлх насны хүүхэд эзэлж байсантай холбоотой Эрүүл мэндийн сайдын 2011 оны 357 дугаар тушаалаар улсын хэмжээнд тархвар судлалын заалтаар 1 нас 2 сартай, 2 настай хүүхдүүдийг дархлаажуулснаар шинэ тохиолдлын тоо 21,5 дахин буурсан үр дүнтэй байна.

Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, эндэгдлийн талаарх мэдээллийг өөрийн орны болон бүс нутгийн улс орнуудтай жишиж гаргасан тоо баримт байна. Тухайлбал Зүүн өмнөд Азийн орнуудад дундажаар 100 000 хүн амд умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн түвшин 10,9, нас баралтын түвшин 4.1 тохиолдол байгаа бол манай улсад 100 000 хүн амд 23,5, нас баралт 10,2 тохиолдол байгаа нь бүс дотроо өвчний дарамт хамгийн өндөр үзүүлэлттэй байгааг илэрхийлж байна. Монгол Улсад умайн хүзүүний хорт хавдар эмэгтэйчүүдэд зонхилон тохиолдох хавдрын 2 дугаарт, нийт хорт хавдрын шинэ тохиолдлоороо 4 дүгээрт, нас баралтаараа 5 дугаарт эрэмбэлэгдэж байна.

“Хүний папиллома вирус (ХПВ)-ийн эсрэг вакцины нөлөөлөл ба зардал-үр дүнгийн шинжилгээ”-г Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын санхүүжилтээр Олон улсын PATH байгууллага, Монгол Улсын Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Хавдар судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хамтран 2018 онд зохион байгуулсан. Вакцины зардлын үр дүн, нөлөөллийг олон улсад тооцдог UNIVAC болон TRIVAC–н загварчлалын дагуу зардал-үр ашгийг 3 хувилбараар тооцон үр дүнг үнэлэхэд вакциныг нэвтрүүлсэнээр үр ашигтай бөгөөд товллолын вакцинд 11 настай хүүхдүүдийг хамруулах нь эдийн засгийн үр дүнтэй гэсэн дүгнэлт гарсан байна.

А вируст гепатитын эсрэг вакциныг Эрүүл Мэндийн Сайдын 2011 оны 357 дугаар тушаалаар улсын хэмжээнд тархвар судлалын заалтаар 2 тунгаар, пневмококкийн эсрэг 13 цэнт вакциныг 3 тунгаар тархвар судлалын заалтаар хийж байна. А вируст гепатитын эсрэг вакцины 4,3 тэрбум, пневмококкийн эсрэг вакцины 3,1 тэрбум, нийт 7,7 тэрбум төгрөгийг улсын төсөвт жил бүр суулгадаг тул төсөвт нэмэлт ачаалал өгөхгүй.

ДЭМБ-ын дархлаажуулалтын зөвлөх бүлгээс (SAGE) хүний папиллома вирусийн эсрэг вакциныг 1 тунгаар тариулахад халдвараас сэргийлэх хангалттай сайн дархлаа тогтож байгаа болохыг нотолсон судалгаануудын үр дүнд үндэслэн зорилтот бүлэгт уг вакциныг 1 тунгаар хийж болохыг улс орнуудад зөвлөсөн байна.

Харин Хүний папиллома вирусийн эсрэг вакциныг заавал хийх дархлаажуулалтын үндэсний товллод 2023 оноос эхлэн нэвтрүүлэхээр төлөвлөсөн бөгөөд зардлын тооцооллоор зөвхөн 11 настай 70 000 гаруй хүүхдийг 1 тунгаар вакцинжуулахаар тооцоход нэг жилд ойролцоогоор 1,5 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгах шаардлага бий болоод байна. Хүний папиллома вирусийн эсрэг вакцины нэг бүрийн үнэ арван есөн мянган төгрөг байна.

Пневмококкийн эсрэг вакцин болон А вируст гепатитын халдварын эсрэг вакцинууд нь заавал хийх дархлаажуулалтад хамрагдах сэргийлэх тарилгын нэр төрөлд орсноор нярай болон бага насны хүүхдийн халдварт өвчний тохиолдол буурах, нас баралт багасах бол хүний папиллома вирусийн эсрэг вакцин нь умайн хүзүүний хорт хавдраас сэргийлж, өвчлөл, нас баралтыг бууруулах эерэг үр дагавар бий болох юм.

Иймд хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, судалгааны үр дүнд үндэслэн “А вируст гепатит, пневмококкийн халдвар, хүний папиллома вирусийн эсрэг сэргийлэх тарилгыг заавал хийх дархлаажуулалтад хамрагдах сэргийлэх тарилгын нэр төрөлд нэмж тусгахаар хуулийн төслийг боловсрууллаа.

Эрүүл Мэндийн Яам